

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавартай нийт 76 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.** Амжилт хүсье.

1. Палеолитын доод шатны үргэлжилсэн цаг хугацаа аль нь вэ? /1 оноо/
 А. 8000-НТӨ III мянган
 В. 800000-100000 жилийн өмнө
 С. 12000-8000 жилийн өмнө
 Д. 100000-40000 жилийн өмнө
 Е. НТӨ III мянганаас- НТӨ IV зуун

2. Мезолитын үеийн гол нээлт аль нь вэ? /2 оноо/
 А. Жад В. Урлагийн үүсэл С. Нум сум Д. Гал Е. Чулуун зэвсэг

3. Хүснэгт доторх асуултын тэмдгийн оронд тохирох үгийг олоорой. /1 оноо/

| Үе | Гол нээлт |
|--------------------|----------------|
| Палеолитын доод үе | Үлдэц, цуулдас |
| Неолитын үе | ? |

- А. Төмөр зэвсэг В. Шидэгч жад С. Зүймэл зэвсэг Д. Ваар сав Е. Гал
4. Хүрлийн үе, түрүү төмрийн үеийн хүмүүс тахилга ба оршуулгын томоохон байгууламж босгодог байжээ. Ийм зориулалттай “Хиргисүүр” хэмээх байгууламж Монгол орны аль хэсгээр тархсан байдаг вэ? /1 оноо/

- А. Зүүн болон өмнөд хэсгээр
 В. Зүүн болон төв хэсгээр
 С. Баруун болон зүүн хэсгээр
 Д. Зүүн болон хойд хэсгээр
 Е. Төв болон баруун хэсгээр

5. Цэгийн оронд тохирох утгыг олно уу /1 оноо/
 Хүрлийн үе түрүү төмрийн үед нүүдэлчдийн нийгэм соёл, аж ахуйн цогц тогтолцоо бүрэлдэж..... бий болов.

- А. Нүүдлийн иргэншил В. Суурин иргэншил С. Төрт улс
 Д. Овог Е. Хотжилт

6. Хань улс “Энх ургийн гэрээ”-г мөрдөхөөс татгалзаж, Хүннүгийн эсрэг дайтах бодлогод хэдэн оноос шилжсэн бэ? /1 оноо/

- А. НТӨ 133 он В. НТӨ 176 он С. НТӨ 141 он
 Д. НТӨ 198 он Е. НТӨ 121 он

7. Хүннү гүрний үед холбогдох түүхэн үйл явдлуудыг зөв дараалалд оруулсан нь аль вэ? /2 оноо/

1. Цинь улс Ордосыг эзлэн авав.
 2. Модунь шаньюй Хань улсын Гаоди хааныг бүслэв.
 3. Хань улс “Энх ургийн гэрээ”-г мөрдөхөөс татгалзаж Хүннүгийн эсрэг дайтах бодлогод шилжив.

- А. 2,3,1 В. 2,1,3 С. 1,2,3 Д. 3,2,1 Е. 1,3,2

8. Сяньби улс задарсан 235 оныг зууны тоололд шилжүүлнэ үү. /1 оноо/

- А. II зууны I хагас В. III зууны I хагас С. III зууны II хагас
 Д. II зууны II хагас Е. I зууны I хагас

9. Дорнод аймгийн Хөх нуурийн Өгөөмөр хэмээх газраас төмөр дөрөө илрүүлсэн нь Монголд хамгийн эртнийх юм. Аль улсын үед хамаарах вэ? /1 оноо/

- А. Жужан В. Хүннү С. Сяньби Д. Түрэг Е. Уйгур



10. **a,b** жагсаалтыг ямар шалгуураар гаргасан бэ? /1 оноо/
 а. Гиюй, Таньшихуай, Шэлүн
 б. Буман, Пэйло, Моюнчур
 А. Монгол нутагт тогтсон төрт улсуудыг үндэслэн байгуулагчдаар
 В. Монгол нутагт тогтсон төрт улсуудын хаадын угсаа гарвалын ялгаагаар
 С. Хаан суусан цаг хугацааны их багаар
 D. Гадагш хийсэн аян дайны цар хэмжээгээр
 E. Эцэг хүүгийн холбоогоор
11. Хятадын төрийн түүх “Түүхэн тэмдэглэл”-д Хүннү нар “могой, нохой өдрийг эрхэмлэнэ” хэмээжээ. Энэ баримтад хийсэн дүгнэлтүүдээс аль нь илүү бодитой вэ? /1 оноо/
 А. Хүннүчүүд гар урлалд могой, нохойг их дүрсэлдэг байжээ.
 В. Тэд могой, нохойг эрхэмлэн шүтдэг байжээ.
 С. Могой, нохой Хүннү нарын амьдралд чухал үүрэгтэй байжээ.
 D. Хүннү нар 12 жил бүхий тооллын цагалбартай байжээ.
 E. Түүхэн тэмдэглэл нь зөвхөн Хүннүгийн тухай зохиол байжээ.
12. Жужан улсад ямар шашин дэлгэрч улмаар төрийн шашин болсон бэ? /1 оноо/
 А. Үнэн алдартны шашин В. Исламын шашин С. Манихейн шашин
 D. Христийн шашин E. Бурхны шашин
13. Амбагай хаан охиноо Татарт хүргэж өгөхдөө баригдаж Алтан улсад хүргэгдэн цаазлуулжээ. Амбагай хааны төрийн бодлого аль нь вэ? /1 оноо/
 А. Эв нэгдлийг сахих
 В. Татар улсад дагаар орох
 С. Татар улсыг эзлэн авах
 D. Татар улсыг ивээлдээ авах
 E. Алтан улсыг эзлэн авах
14. X-XII зууны Монгол улсын үндсэн нутаг аль нь вэ? /2 оноо/
 А. Онон, Хэрлэн, Туул гурван голын эхээр
 В. Хэрлэнгийн дунд урсгал, Сэлэнгэ голын саваар
 С. Туул, Орхон голын саваар
 D. Алтайн, Хангайн нурууг дамнан Эрчис гол хүртэлх нутаг
 E. Хөлөн, Буйр нуурын орчмоор
15. Монгол аймаг улсуудыг газар нутагтай нь зөв тохируулсныг сонгоорой. /2 оноо/
 1. Ойн иргэд а. Алтайн, Хангайн нурууг дамнан Эрчис мөрөн хүртэлх
 2. Найман улс б. Байгаль нуур, Баргужин төхөм, Горлог мөрний сав
 3. Мэргид в. Орхон голын адаг
 А. 1с, 2а, 3б В.1с, 2б, 3а С.1б, 2с, 3а
 D. 1б, 2а, 3с E.1а, 2б, 3с
16. Монгол улсыг довтлохоор зэхэж байсан Найман улсыг Чингис хаан хэдэн онд мөхөөн дагуулсан бэ? /1 оноо/
 А. 1206 он В.1201 он С.1204 он D. 1203 он E. 1202 он
17. Чингис хааны хишигтэн цэргийн үүргийг зөв тохируулсныг олно уу. /1 оноо/
 А. Хэвтүүл-өдрийн манаа, Торгууд-шадар цэрэг, Хорчин- шөнийн манаа
 В. Хэвтүүл-шөнийн манаа, Торгууд-шадар цэрэг, Хорчин- өдрийн манаа
 С. Хэвтүүл-шөнийн манаа, Торгууд-өдрийн харуул, Хорчин- шадар цэрэг
 D. Хэвтүүл-шадар цэрэг, Торгууд-шөнийн манаа, Хорчин- өдрийн манаа
 E. Хэвтүүл-өдрийн манаа, Торгууд-шөнийн манаа, Хорчин- шадар цэрэг
18. Монголын Ил хаант улсын нийслэлийг сонгоно уу. /1 оноо/
 А. Алмалиг В. Дайду С. Сарай D. Марага E. Аксу



19. Их Юань улсын захиргаанд байсан улс орнуудыг зөв тодорхойлсон нь аль вэ? /2 оноо/
 А. Хятад, Солонгос, Ирак, Бага Ази
 В. Монгол, Иран, Афганистан, Бага Ази
 С. Иран, Ирак, Азербайжан, Армян
 D. Турк, Афганистан, Перс, Араб
 E. Монгол, Хятад, Солонгос, Өмнөд Ази
20. Монголын төр хэзээ Хятад газраас эх нутагтаа эргэн ирсэн бэ? /1 оноо/
 А. 1368 он В. 1374 он С. 1378 он D. 1388 он E. 1380 он
21. Түүхэнд тэмдэглэгдсэн “Түмү-гийн хэрэг” гэгч аль нь вэ? /2 оноо/
 А. Алтан хан 1557 онд Хөх нуурыг довтолсон явдал
 В. 1452 онд Эсэн тайш Тайсун хааныг хороож хаан болсон явдал
 С. Боди-Алаг хаан ах Гүнбилэгийн хамт Урианхай түмнийг 6 удаа довтолсон явдал
 D. 1449 онд Эсэн тайш Мин улсын Инзүн хааныг олзолсон явдал
 E. Түмэн засагт хаан зүүн, баруун түмнийг эвлэрүүлэх Төв засгийн газар байгуулсан явдал
22. XV-XVI зууны үеийн Зүүн Монголын жононгийн шууд захиргаанд байдаг, баруун гурван түмэнг зөв ялгасан хувилбар аль нь вэ? /2 оноо/
 1.Цахар 2. Ордос 3. Түмэд 4. Халх 5. Урианхай 6. Юншээбү
 А. 1, 4, 5 В. 2, 4, 5 С. 2, 3, 6 D. 1, 2, 3 E. 4, 5, 6
23. Батмөнх даян хааны үед Халх түмэн нь Арын 7 отог, Өврийн 5 отгоос бүрдэж байсан ба Арын 7 отгийг түүний хөвгүүн хэн өвлөн захирч байсан бэ? /1 оноо/
 А. Алчуболд В. Гэрсэнз С. Агваржин D. Боди-Алаг E. Гүнбилэг
24. **Далай лам:** Өдгөө Шарын шашны тэргүүнээр XIV Далай лам Данзанжамц заларч буй бөгөөд 1989 онд Нобелийн энх тайвны шагнал хүртсэн юм. Далай ламын бүх дүр Монголын түүхтэй ямар нэгэн сэжмээр холбогддог билээ.
 Монголоос тодруулсан IV Далай лам хэний гэрт мэндэлсэн бэ? /1 оноо/
 А. Абтай сайн хан В. Алтан хан С. Гэрсэнз
 D. Сүмир хунтайж E. Хутагтай сэцэн хунтайж
25. Амарбаясгалант хийдийг хэзээ, хэний дурсгалд зориулан барьсан бэ? /2 оноо/
 А. 1586 онд Абтай сайн хан
 В. 1748 онд Агваанжамбалданзан
 С. 1577 онд Алтан хан
 D. 1576 онд Түмэн засагт хаан
 E. 1727 онд Занабазар
26. Дараах ойлголтуудыг утгаар нь зөв тохируулсныг сонгоорой. /2 оноо/
 1. Соёмбо үсэг а. Намхайжамц
 2. Али гали үсэг b. 1587 он
 3. Тод үсэг c. Занабазар
 А. 1с, 2b, 3a В. 1с, 2a, 3b С. 1a, 2b, 3c
 D. 1b, 2с, 3a E. 1a, 2с, 3b
27. Халх Монголыг Манжийн харьяанд оруулах ёслол хэзээ, хаана болсон бэ? /1 оноо/
 А. 1640 онд Тарвагтайн Улаан бураа
 В. 1686 онд Хүрэн бэлчир
 С. 1689 онд Ар элстэйд
 D. 1691 онд Долоон нуурт
 E. 1636 онд Мүгдэнд



28. 1638 онд Манжийн хаан Халхын 3 ханыг жил бүр ямар алба барьж, байх зарлиг буулгасан бэ? /2 оноо/
 А. Өртөөний алба
 В. Ангийн үсний алба
 С. 9 цагааны алба
 D. Харуулын алба
 E. Малаар алба хаах
29. “Буурын гэрээ”-гээр Оросын эзэнт улс ба Манж Чин улсын хилийн заагийг тогтоосноор Буриад монголчууд Оросын эзэнт улсын мэдэлд оржээ. Уг гэрээ хэдэн онд болсон бэ? /1 оноо/
 А. 1771 онд В. 1630 онд С. 1689 онд D. 1607 онд E. 1727 онд
30. 1617 онд Авга хар ууланд Цагаан хотыг байгуулсан хаан хэн бэ? /1 оноо/
 А. Цэвээнравдан хаан В. Аюук хаан С. Галдан хаан
 D. Лигдэн хаан E. Буян сэцэн хаан
31. Монгол улс тусгаар тогтнолоо алдсан дотоод шалтгаануудаас **ИЛҮҮЦ** нь аль вэ? /2 оноо/
 А. Эрх мэдлийн хувиарлалт алдагдсан.
 В. Хувийг ашиг сонирхол ихэссэн.
 С. Хагалан бутаргах бодлого явагдсан.
 D. Өвөр зуураа өрсөлдөн тэмцэлдсэн.
 E. Их хааны сүр хүч буурсан.
32. 1723 онд болсон Хөхнуур, Төвөдийн бие даасан байдлыг хадгалахын төлөө Лувсанданзан тэргүүтэй ноёдын бослого Зүүн гарын хаант улсаас тусламж авч чадаагүй гол шалтгаан аль нь вэ? /1 оноо/
 А. Төвөдийн ноёд Лувсанданзанг дэмжээгүй.
 В. Цэвээнравдан хаантай дайсагнасан харилцаатай байсан тул
 С. Халхын II Богд Жавзандамба хутагт туслаагүй.
 D. Олон ноёд харьяатаа авч Манжид урвасан.
 E. Энгийн ард олон дэмжиж оролцоогүй.
33. Монголчуудын тусгаар тогтнолын төлөөх тэмцэл хөдөлгөөнүүдийг он цагийн зөв дараалалд оруулсан хариултыг сонгоорой. /2 оноо/
 1. Байлинга, Мясэнгэ удирдсан бослого
 2. Цогдалайн удирдсан бослого
 3. Амарсанаа, Чингүнжав нарын удирдсан бослого
 А. 1, 3, 2
 В. 1, 2, 3
 С. 2, 3, 1
 D. 3, 1, 2
 E. 3, 2, 1
34. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын түүхэн ач холбогдол аль нь вэ? /1 оноо/
 А. Хятад худалдаачдын тоо багассан.
 В. Манжийн амбан сайдыг хөөн гаргасан.
 С. Манжийн алба татвараас чөлөөлөгдсөн.
 D. Манжийн төрийн хуулийг дагаж мөрдөхөө больсон.
 E. Манжийн эрхшээлээс гарч тусгаар тогтнолоо сэргээсэн.
35. 1913 онд “Монгол улсын хязгаарын доторх олон зүйлийн уурхайг нээн шийтгэх дүрэм хэмжээ”-г батлав. Дүрэмд зааснаар олборлосон цагаан алт, очир алмас, эрдэнийн чулууны орлогын хэдэн хувийг татварлах болсон бэ? /1 оноо/
 А. 20-50% В. 5-10% С. 10-15% D. 20-30% E. 30-60%
36. Дээд, доод танхим бүхий Улсын хурлыг хэдэн онд байгуулсан бэ? /1 оноо/
 А. 1914 онд В. 1911 онд С. 1913 онд
 D. 1918 онд E. 1919 онд



37. Улиастайг чөлөөлсөн 1912 оныг билгийн тоололд шилжүүлнэ үү /2 оноо/

Доорх өгөгдлийг ашиглаж бодоорой.

| Аргын оныг билгийн жилд шилжүүлэх арга | Махбодь жил | Гал | Шороо | Төмөр | Ус | Мод |
|--|-------------|-----|-------|-------|----|-----|
| Аргын оныг билгийн жилд шилжүүлэхдээ тухайн аргын оноос 1026-г хасч, гарсан ялгаврыг 60-д хуваасны бүхэл үлдэгдэл нь олох билгийн жилийн дугаар бөгөөд ноогдвор дээр 1-ийг нэмбэл олох билгийн жилийг харьяалах жарны дугаар гарна. Хүснэгтэд буй дугаараар билгийн жил хийгээд түүнийг махбодыг олно. | Туулай | 1 | 13 | 25 | 37 | 49 |
| | Луу | 50 | 2 | 14 | 26 | 38 |
| | Могой | 51 | 3 | 15 | 27 | 39 |
| | Морь | 40 | 52 | 4 | 16 | 28 |
| | Хонь | 41 | 53 | 5 | 17 | 29 |
| | Бич | 30 | 42 | 54 | 6 | 18 |
| | Тахиа | 31 | 43 | 55 | 7 | 19 |
| | Нохой | 20 | 32 | 44 | 56 | 8 |
| | Гахай | 21 | 33 | 45 | 57 | 9 |
| | Хулгана | 10 | 22 | 34 | 46 | 58 |
| | Үхэр | 11 | 23 | 35 | 47 | 59 |
| | Бар | 60 | 12 | 24 | 36 | 48 |

- A. XV жарны усан гахай жил
 B. XIV жарны усан хулгана жил
 C. XV жарны усан хулгана жил
 D. XIV жарны усан бар жил
 E. XVII жарны усан нохой жил

38. Ардын засгийн газрын бүтцийг зөв тохируулсан нь аль вэ? /2 оноо/

- A. Ерөнхий сайд-Д.Бодоо, Дотоод яам-С.Данзан, Сангийн яам- Д.Пунцагдорж
 B. Ерөнхий сайд-Д.Бодоо, Дотоод яам-Д.Пунцагдорж, Сангийн яам- С.Данзан
 C. Ерөнхий сайд-Д.Бодоо, Дотоод яам-Н.Магсаржав, Сангийн яам- Д.Сүхбаатар
 D. Ерөнхий сайд-Д.Бодоо, Дотоод яам-Х.Чойбалсан, Сангийн яам- Д.Догсом
 E. Ерөнхий сайд-Д.Бодоо, Дотоод яам-Д.Лосол, Сангийн яам- Д.Чагдаржав

39. Судар бичгийн хүрээлэн хэдэн онд байгуулагдсан бэ? /1 оноо/

- A. 1924 он B. 1922 он C. 1923 он D. 1921 он E. 1925 он

40. Монгол, Зөвлөлт Орос Улс хоёрын 1921.11.05-ны өдөр байгуулсан гэрээний агуулга аль нь вэ? /2 оноо/

- A. Тангарагийн гэрээг батлан мөрдүүлэх тухай
 B. Цагаантны үлдэгдлийн эсрэг цэргийн ажиллагааг үргэлжлүүлэх тухай
 C. Хятадын эсрэг эдийн засгийн талаар хамтран ажиллах тухай
 D. Эзэн хамжлагын харилцааг халах тухай
 E. Хоёр улс засгийн газруудаа харилцан хүлээн зөвшөөрч, бүрэн эрхт төлөөлөгч суулгах тухай

41. Анхдугаар Үндсэн хуулийг хэдэн онд баталсан бэ? /1 оноо/

- A. 1940 он B. 1960 он C. 1992 он D. 1924 он E. 1922 он

42. 1922 оны 05 дугаар 29-нд байгуулагдсан Үндсэн хууль боловсруулах комиссын гишүүдийг олно уу. /1 оноо/

- A. Ж.Цэвээн, Ч.Бат-Очир B. Б.Цэрэндорж, Ч.Дамбадорж
 C. Х.Чойбалсан, Д.Лосол D. Ж.Цэвээн, Д.Догсом
 E. Догсом, Х.Чойбалсан.

43. Шинэ эргэлтийн бодлогын агуулгад аль нь **ХАМААРАХГҮЙ** вэ? /1 оноо/

- A. Социализмын үндэс суурийг байгуулах
 B. Хувийн хөдөлмөр худалдааг хөгжүүлэх
 C. Шашин шүтлэгийг бүрэн чөлөөтэй болгох
 D. Ардын засгийн газрийг бэхжүүлэх
 E. Үндэсний ардчилсан үзлийг чиг баримжаа болгох

44. Зүүнтний алдаатай бодлогоор 16.3 сая болтол хорогдсон мал сүрэг 1940 он гэхэд хэд болж өссөн бэ? /2 оноо/

- A. 30 сая B. 20 сая C. 25 сая D. 26 сая E. 31 сая



45. 1935 оны 01 сард Япон улс БНМАУ-д халдаж эзэлсэн газар нутгийг олно уу. /1 оноо/
 А. Хөлөн буйрын орчмын нутаг
 В. Байтаг Богд уул
 С. Халхын сүм орчмын нутаг
 D. Алтайн өвөр бие
 E. Мэнэнгийн тал
46. Атрын анхдугаар аян хэдэн оноос эхэлсэн бэ? /1 оноо/
 А. 1961 он В. 1959 он С. 1976 он D. 2008 он E. 1982 он
47. БНМАУ, 1972 онд Япон улстай дипломат харилцаа тогтоожээ. Энэ онд дипломат харилцаа тогтоосны хэдэн жилийн ой болох вэ? /2 оноо/
 А. 61 жилийн ой В. 59 жилийн ой С. 48 жилийн ой
 D. 51 жилийн ой E. 58 жилийн ой
48. БНМАУ-тай дипломат харилцаа тогтоосон улс орнуудын он цагийг зөв тохируулсныг сонгоорой. /2 оноо/
 1. Австри а. 1965 он
 2. Франц б. 1974 он
 3. ХБНГУ с. 1963 он
 А. 1а, 2с, 3b
 В. 1с, 2b, 3а
 С. 1b, 2с, 3а
 D. 1b, 2а, 3с
 E. 1с, 2а, 3b
49. Монголын ардчилсан холбооны анхны цуглаан хэзээ болсон бэ? /1 оноо/
 А. 1990 оны 01 сарын 21
 В. 1990 оны 02 сарын 18
 С. 1989 оны 12 сарын 09
 D. 1989 оны 12 сарын 10
 E. 1990 оны 03 сарын 07
50. Ардчилсан хүчнийхэн 1990.03.08-ны орой мэдэгдэл гаргахдаа ямар шаардлагыг гол болгож тавьсан бэ? /2 оноо/
 А. МАХН-ын аппаратыг төрийн ордноос гаргах
 В. МАХН-ын үйл ажиллагааг зогсоох
 С. МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчоог огцруулах
 D. МАХН-ын түүхийг үнэн бодитой шинэчлэн боловсруулах
 E. МАХН-ын үйл ажиллагааг төрөөс ангид байлгах
51. Цэгийн оронд тохирох үгийг олно уу. /1 оноо/
 1996 оны 06-р сарын 30-нд явагдсан сонгуульд...../нам, эвсэл/ ялалт байгуулж, 50-н суудал, Монголын уламжлалын нэгдсэн нам 1 суудал авчээ.
 А. Монгол Ардын Хувьсгалт Нам
 В. Ардчилсан холбоо эвсэл
 С. Монголын Социал Демакрат Нам
 D. МАХН-Эх орон-Ардчилал эвсэл
 E. Монголын Үндэсний Дэвшилтэд нам
52. 1992 оны Үндсэн хуулийн дагуу явагдсан Монгол улсын Ерөнхийлөгчийн анхны сонгуульд хэн, хэн өрсөлдсөн бэ? /1 оноо/
 А. П.Очирбат, Э.Бат-Үүл
 В. П.Очирбат, Д.Батбилэг
 С. Л.Түдэв, П.Очирбат
 D. Н.Багабанди, Л.Түдэв
 E. Н.Багабанди, С.Зориг
53. Мэгжид Жанрайсиг шүтээнийг бүтээн залах ажлыг Ерөнхийлөгчийн зарлигаар гүйтэтгэж, хэдэн оны намар Гандантэгчинлэн хийдэд залсан бэ? /1 оноо/
 А. 2007 он В.1998 он С. 2004 он D. 1996 он E. 2000 он



54. Ардчилсан хувьсгал гарснаас хойш эзэн богд Чингис хаанаа дээдлэн сүслэх болж, төрийн ордны өмнө ямар хаадуудын хөшөөг сүндэрлүүлсэн бэ? /2 оноо/
- A. Чингис, Өгэдэй, Мөнх
 - B. Чингис, Өгэдэй, Гүюг
 - C. Чингис, Гүюг, Хубилай
 - D. Чингис, Мөнх, Хубилай
 - E. Чингис, Өгэдэй, Хубилай
55. 2014 онд Монгол улсын гадаад харилцаанд болсон онцлог үйл явдал аль нь вэ? /1 оноо/
- A. БНХАУ-ын дарга Ши Жиньпин айлчлав.
 - B. Японы ерөнхий сайд Тошкү Кайфу айлчлав.
 - C. АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш айлчлав.
 - D. НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга К.Аннан айлчлав.
 - E. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал анх удаа батлагдав.
56. Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын аль чиглэлд хамаарах вэ? /1 оноо/
- A. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах
 - B. Хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах
 - C. Дотоод аюулгүй байдлыг хангах
 - D. Хүний аюулгүй байдлыг хангах
 - E. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах



ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай тус бүр 6 оноотой нийт 24 оноотой. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

2.1 Чулуун зэвсгийн үеийн он цагийг зөв тохируулахдаа 1-7 хүртэлх өгөгдлөөс сонгож харгалзуулна уу. /1 өгөгдөл илүүг анхаарна уу/ /6 оноо/

- | | |
|------------------|----------------------------------|
| A. Палеолит | 1. 8000-НТӨ III мянган |
| b. Мезолит | 2. 100000-40000 жил |
| c. Неолит | 3. 800000-12000 жил |
| d. Доод палеолит | 4. 40000-12000 жил |
| e. Дунд палеолит | 5. 12000-8000 жил |
| f. Дээд палеолит | 6. 800000-100000 жил |
| | 7. НТӨ III мянганаас-НТӨ IV зуун |

2.2 Монголын бүрэлдэхүүн улсуудын хаадыг зөв харгалзуулна уу. /6 оноо/

- | | |
|-----------------|--------------------|
| a. Хубилай | 1. Газан |
| b. Хүлэгү | 2. Тогоонтөмөр |
| c. Бат | 3. Цагайдайн улс |
| d. Юань улс | 4. Ил хаант улс |
| e. Цагадай | 5. Алтан ордны улс |
| f. Ил хаант улс | 6. Юань улс |

2.3 Монголын хаант улсуудын үеийг холбогдох ойлголттой нь зөв харгалзуулна уу. /6 оноо/

- | | |
|----------------|--|
| a. Хошууд улс | 1. Хангайн нурууны бүс нутаг, Алтайн нурууны зарим хэсэг |
| b. Ойрад | 2. Туул голын хөндий, Орхоны дээд бие Тамирын голын сав |
| c. Өвөр Монгол | 3. Хэрлэн голын сав нутаг |
| d. Түшээт хан | 4. Монголын баруун хэсэгт оршиж, 4-н голлох аймагтай |
| e. Засагт хан | 5. Хөх нуур, Төвөдийн нутагт оршиж байсан. |
| f. Сэцэн хан | 6. Цахар, Түмэд Ордос зэрэг аймгуудас бүрдэж байсан. |

2.4 1921 оны хувьсгалын түүхэн гол үйл явдлуудыг зөв харгалзуулна уу /6 оноо/

- | | |
|-------------------------|---|
| a. 1921 оны 2 сар | 1. Барон Унгерн Нийслэл хүрээг эзлэн авав. |
| b. 1921 оны 3 сарын 1-3 | 2. Хиагтад байгаа гамин цэрэгт шаардах бичиг өгөв. |
| c. 1921 оны 03 сарын 17 | 3. Дээд Шивээнд /Тройцкосавскд/ эрмэлзэх 10-н зүйлийг батлав. |
| d. 1921 оны 06 сарын 28 | 4. Засгийн эрх шилжүүлэх ёслол болж Ардын засгийн газар байгуулагдав. |
| e. 1921 оны 02 сарын 04 | 5. Д.Сүхбаатарыг цэргийн жанжнаар томилов. |
| f. 1921 оны 07 сарын 10 | 6. Ардын түр засгийн газар МАН-ын ТХ-ны хамтарсан хурлаас Нийслэл хүрээг чөлөөлөх шийдвэр гаргав. |

